



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/571

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалт, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйл 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)


- Гишүүд:
- (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
 - (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
 - (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
 - (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
 - (Иргэний төлөөлөл)
 - (Тогтвортой амжиргаа-3 төслийн орон нутгийн ажилтан)
 - (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Энэхүү журам гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/566 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР